## 6.0. Ойлголт

**Сургалтын орчин** гэсэн модуль нь **байр** болон **өрөөний** мэдээллийн хэсгийн бүртгэлийг хөтлөдөг. **Байрны мэдээлэл нь** тухайн цэцэрлэгийн барилгын ерөнхий мэдээллийг агуулах бөгөөд үүнд Стандартын эсэх, ашиглаж байгаа эсэх, актлагдсан эсэх, эзэмшлийн төрөл, хүчин чадал, анхны өртөг, сүүлийн өртөг, хаяг гэх мэт мэдээллийг харуулна.

Өрөөний мэдээлэл нь өрөөний төрөл, танхимын төрөл, гэрчилгээтэй эсэх, багтаамж, эд хогшил, бүрэлдэхүүнтэй эсэх мэдээллийг оруулна.




---

## 6.1. Шинэ байр бүртгэх

Шинэ байр бүртгэх үйлдлийг хийхэд дараах дарааллыг баримтлана. Үүнд:

1. **Боловсролын Удирдлага** системийн **Сургалтын орчин** үйл ажиллагааг сонгоно.




2. Цонхны баруун дээд хэсэгт байрлах шинэ байр товч дээр дарна.



3. Шинэ байр товч дээр дарж оруулах байрны үндсэн мэдээллийг оруулан хадгалах үйлдэл хийнэ.



***Анхаарах нь:***

- *Хэрэв тухайн 1 байрыг олон зориулалтаар ашигладаг бол үндсэн зориулалт талбарт гол зориулалтыг сонгоод бусад зориулалтыг нэмэлт зориулалт хэсэгт нэмж бүртгэх*
- *Засвар үйлчилгээ хэсэгт их засвар хийсэн түүх, урсгал засварын түүхийг бүртгэх*
- *Дэд бүтэц хэсэгт халаалт, инженерийн шугам сүлжээ, эрчим хүчний мэдээллийг бүртгэх*

---

## 6.2. Байрны мэдээлэл засах

Байрны мэдээлэл засах үйлдлийг хийхэд дараах дараалллыг баримтлана. Үүнд:

1.**БУ системийн Сургалтын орчин** үйл ажиллагааг сонгоно.




2.Үүссэн байрны жагсаалтаас **засах** байрыг сонгоно.

3.**Үйлдэл** цэснээс **байрны мэдээлэл засах** үйлдлийг дарна.



4.**Байрны мэдээлэл засах** цонхны мэдээллийг засч, хадгална.



**Байрны мэдээлэл засах** цонхны талбарын мэдээллийг засаж **хадгалах** товчийг дарснаар таны засаж, өөрчилсөн мэдээлэл хадгалагдана. Талбар бүр дэх мэдээллийг өөрчилж, засах боломжтой.

---

### 6.3. Байрны мэдээлэл устгах

Байр устгах үйлдлийг хийхэд дараах дарааллыг баримтлана. Үүнд:

1. **БУ системийн Сургалтын орчин** үйл ажиллагааг сонгоно.




2. Байрны жагсаалтаас **устгах** байрыг сонгоно.
3. **Үйлдэл** цэснээс **байр устгах** үйлдлийг дарна.




4. Жагсаалтаас устгах байрыг сонгоод үйлдэл цэснээс **байр устгах** гэсэн үйлдлийг дарахад дараах дэд цонх нээгдэнэ.




---

### 6.4. Шинэ өрөө үүсгэх

Энэхүү үйлдлийг сургалтын үйл ажиллагаа явуулахад ашиглаж байгаа байрыг систем дээр үүсгэсний дараа түүнд байрлах өрөө бүрийг шинээр үүсгэхэд ашиглана.

Шинэ өрөө үүсгэхээс өмнө системд **дараах үйлдлийг** хийсэн байх ёстой.

- Бүртгэх гэж буй өрөө байрлах **байр**ыг БУС-ийн сургалтын орчин үйл ажиллагааны байр таб-д шинэ

байр үйлдлээр бүртгэсэн байх. (нэмэлт зориулалтаар ашигладаг байрны өрөө, танхимыг бүртгэхээс өмнө тухайн бүртгэсэн байрны нэмэлт зориулалт хэсэгт уг байрыг бүртгэж өгсөн байх)

Шинэ өрөө үүсгэх үйлдлийг хийхэд дараах дараалдлыг баримтлана. Үүнд:

1. **БУ системийн Сургалтын орчин** үйл ажиллагааг сонгоно.




2. **Шинэ өрөө** үйлдлийг дарна.




3. **Шинэ өрөө** бүртгэлийн цонхны мэдээллийг оруулж хадгална.

4. Шинэ өрөө товч дээр дарахад дараах бүртгэл оруулах хэсэг харагдах бөгөөд өрөөний мэдээллийг оруулан хадгалах товч дарна.



## 6.5. Өрөөний мэдээлэл засах

Өрөөний мэдээлэл засах үйлдлийг хийхэд дараах дараалдлыг баримтлана. Үүнд:

1. **БУ системийн Сургалтын орчин** үйл ажиллагааг сонгоно.




2. Үүссэн өрөөний жагсаалтаас **засах** өрөөг сонгоно.

3. **Үйлдэл** цэснээс **өрөөний мэдээлэл засах** үйлдлийг дарна.




4. **Өрөөний мэдээлэл засах** цонхны мэдээллийг засч, хадгална.




## 6.6. Өрөөний мэдээлэл устгах

Өрөө устгах үйлдлийг хийхэд дараах дарааллыг баримтлана. Үүнд:

1. **БУ системийн Сургалтын орчин** үйл ажиллагааг сонгоно.




2. Өрөөний жагсаалтаас **устгах** байрыг сонгоно.

3. **Үйлдэл** цэснээс **өрөө устгах** үйлдлийг дарна.




4. Устгах дэд цонхонд тийм товчийг дарснаар өрөө устана.

